



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 312
танай _____ -ны № _____ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгуулагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ "Төрийн аudit MNS 6817 - 1 : 2020" Тулгуур зарчим, "Төрийн аudit MNS 6817 - 6 : 2020" Нийцлийн аудитын зарчим, "Төрийн аudit MNS 6817 - 8 : 2020", Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, "Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг", Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О. Чинзориг

Л.ЛАМААЧИН

Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын МАН-ын
хорооны тэргүүлэгчдийн 2020 оны 06 дугаар сарын 10-ны
өдрийн 03тоот тогтоолын хавсралт

ХАЙРХАНДУЛААН СУМЫН МАН-ААС 2020 ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Эрхэм зорилго.

Бүх нийтийн хамтын оролцоо, бүтээлч үйл ажиллагааг чухалчилан хүний
амьдрах, ажиллах, хөгжих таатай орчинг бүрдүүлж, байгаль орчинд ээлтэй, хөдөө
аж ахуйд суурилсан хөгжлийг ханггад оршино.

Зорилт.

Нэг. Нийгмийн хөгжлийн бодлого

- Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир
- Боловсрол, соёл урлаг, гэр бүл, хүүхэд залуучууд
- Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж

Хоёр. Эдийн засаг, орон нутгийн хөгжлийн бодлого

- Төсөв санхүү, эдийн засаг
- Дэд бүтэц, хөрөнгө оруулалт
- Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ
- Байгаль орчин, газрын харилцаа

Гурав. Засаглалын бодлого

- Төрийн алба, хууль эрх зүй

Нэг. Нийгмийн хөгжлийн бодлого

1.1. Эрүүл мэнд, нийтийн биеийн тамир

1. Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр эрүүл гэр бүл, байгууллага, баг, сум болох хөдөлгөөнийг өрнүүлж, хүний зан үйлтэй холбоотой өвчлөлөөс сэргийлэх ажилд иргэд, хамт олны оролцоог нэмэгдүүлнэ.
2. Хөдөөгийн багийн иргэдэд “ИРГЭН- ЭРҮҮЛ МЭНД” явуулын эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг тогтмол хугацаанд үзүүлж хэвшинэ.
3. Сумын эрүүл мэндийн төвийг шаардлагатай эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, эмч, сувилагчдын ур чадварыг дээшлүүлж, эмчилгээ, үйлчилгээний чанарыг сайжруулна.
4. Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, урсгал засварыг хийнэ.
5. Түргэн тусlamжийн авто машинд засвар, үйлчилгээг бүрэн хийнэ.
6. Явган болон дугуйн аялалыг бүх талаар дэмжиж, нийтийн биеийн тамирыг эрчимжүүлнэ.
7. Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ТББ, холбоод, клубүүдийг дэмжин хамтран ажиллана.
8. 2 жил тутамд багуудын урлаг, спортын наадмыг уламжлал болгон зохион байгуулна.
9. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх бодлого боловсруулж “Спортлог-Хайрхандулаан” аяныг өрнүүлнэ.

1.2. Боловсрол, соёл урлаг, гэр бүл, хүүхэд, залуучууд

1. 5 настай хүүхдийг СӨБ-ын үйлчилгээнд бүрэн хамруулж, хамран сургалтыг 80 хувьд хүргэнэ.
2. Хүүхдийн цэцэрлэгийг мэргэжлийн дуу хөгжмийн багштай болгоно.
3. СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийг гэр булийн орчинд хөгжүүлэх сургуульд бэлтгэх ажлыг эцэг эх, асран хамгаалагч, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын оролцоонд тулгуурлан үр дүнтэй зохион байгуулна.
4. Цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилнэ.
5. Иргэд олон нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, “Эко сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



Handwritten signatures and initials, likely belonging to the author or relevant officials, are placed at the bottom right of the document. The signatures are cursive and include what appears to be "Н.Н.Т." and "20".

6. Сургуулийн номын санг цахим болгож, сурагчдын дунд “Номтой нөхөрлөө” аяныг зохион байгуулна.
7. Сурагчдын дугуйлан секцийн чанар хүртээмжийг сайжруулж, аймаг, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход бүхий л талын дэмжлэг үзүүлнэ.
8. Багш нарын мэдлэг, ур чадварыг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтанд хамруулж, тэдний нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.
9. Дотуур байрны хатуу болон зөөлөн эдлэлийг шинэчилнэ.
10. Зарим ангиудын багш, сурагч сандал, ширээг шинэчилнэ.
11. Сургуулийн хичээлийн байрны гадна болон дотор засварыг хэсэгчлэн хийж, сантехникийн их засварыг хийнэ.
12. Сүүлийн үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжүүдийг сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэн анги, танхимын тохижилт, кабинетын тоог нэмэгдүүлэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
13. Иргэдийн санаачилгаар “Ургийн баяр” зохион байгуулахыг дэмжин “Угийн бичиг” хөтлөлтийг нэмэгдүүлнэ.
14. Соёлын төвийн хөгжим, техник хэрэгслийг шинэчилнэ.
15. Суманд улсын болон орон нутгийн төсвөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажилд залуучуудыг татан оролцуулна.
16. Баялаг бүтээгч залуучуудыг бодлогоор дэмжин ажиллана.
17. Шинэ гэр бүлүүдийг бодлогоор дэмжинэ.

1.3. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж

1. Байнгын ажлын байрыг бий болгосон, хадгалсан иргэн, аж ахуй нэгжийг дэмжих бодлого баримтална.
2. Цөөн малтай залуу малчдыг малжуулах төсөл, хөтөлбөрт хамруулна.
3. Байнгын болон түр ажлын байранд иргэдийг зуучилж, зорилтот бүлгээс хамруулах бодлогыг баримтална.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин нийгмийн хамгааллыг сайжруулна.
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг шаардлагатай тэргэнцэр болон тусгай хэрэгслээр үе шаттай хангана.
6. Зорилтот бүлгийн иргэдийн нөхцөл байдалд судалгаа хийн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрах хүрээг оновчтой тогтоож хүртээмжийг сайжруулна.

Хоёр. Эдийн засаг, орон нутгийн хөгжлийн бодлого


25

2.1. Төсөөв санхүү, эдийн засаг

1. Монгол улсын татварын өөрчлөлт, шинэчлэлтийн бодлогыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, аймаг, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.
2. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байх бодлогыг хэрэгжүүлж, төсвийн хэтрэлтгүй ажиллана.
3. Орон нутгийн хөгжлийн хетөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаад, дотоодын төсөл, хетөлбөрийн хөрөнгийг татаж үр дүнтэй ашиглана.
4. Улс, орон нутгийн төсвийн урсгал болон хөрөнгийн зардлаар худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нийлүүлэлт, гүйцэтгэлд иргэд, олон нийт хяналт тавих нөхцлийг бүрдүүлнэ.
5. Эрүүл мэндийн даатгалын хуулийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, иргэдийг даатгалд хамруулж, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ бүрэн авахад дэмжлэг үзүүлнэ.

2.2. Дэд бүтэц, хөрөнгө оруулалт

1. Улсын өсөх идэр начин Ш.Жанцандоржийн нэрэмжит Цэцэрлэгт хүрээлэнг тохижуулна.
2. Сумын төв доторхи засмал замыг засварлан өнгөлж асьфалтаар хучиж, зарим газруудад сунгана.
3. Гэр хорооллын гэрэлтүүлгийн урсгал засварыг хийж, шаардлагтай газруудад нэмэгдүүлнэ.
4. Халуун усыг засварлах, нэмэлт үйлчилгээ бий болгох, орчин нөхцлийг сайжруулна.
5. Хуучин соёлын төвийг буулган “Бидний бахархал” хүндэтгэлийн цогцолбор байгуулна.
6. ЕБС-ийн хуучин 52 хүүхдийн байрыг засварлаж түрээсийн байрны зориулалтаар ашиглана.
7. Сумын дээд гүүрийг засварлаж, иргэдийн хүсэлт гаргадаг зарим газарт шинээр гүүр барьна.
8. Ундны усны худгуудын ашиглалтыг сайжруулж, ухаалаг болгоно.
9. “Хийморь” хорооллыг цахилгаан эрчим хүч, усан хангамжийн найдвартай эх үүсвэрээр хангана.
10. Дулааны шугам сүлжээнд холбогдох боломжтой аж ахуй нэгж, айл өрхүүдийг холбох ажлыг зохион байгуулна.
11. “Зулуус” хаус хорооллыг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор барьж, инженерийн шугам сүлжээнд холбоно.

26

12. Нийтийн тээврийн үйлчилгээнд орон нутгийн оролцоог нэмэгдүүлж, аж ахуй нэгжтэй хамтарч ажиллана.

2.3. Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ

1. ХАА-н салбарын мэргэжилтнүүдийг гадаад, дотоодын төрөлжсөн сургалтанд хамруулах, мэдлэг чадварыг дээшлүүлж туршлага судлуулна.
2. Мал эмнэлгийн үйлчилгээний тогтолцоог оновчтой болгож, малын халдварт өвчинеөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанартай зохион байгуулж, празитлах /угаалга, туулга/ өвчинеөс эмчлэх, сэргийлэх арга хэмжээнд 100 хувь хамруулна.
3. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор гар болон инженерийн худгийг тус бүр 5-аас доошгүй засварлаж, шаардлагатай газруудад шинээр худаг гаргана.
4. Мал сүргийг ээмэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
5. Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээний тодорхой хувийг хангана.
6. Газар тариалан эрхлэгчдийг өвлийн хүлэмж барихад дэмжлэг үзүүлнэ.
7. Иргэдийн өвөлжөө, хаваржааны хашаа, саравчаа засварлах, шинээр барихад хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.
8. Малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлж, тээлийн хөндийд төрөл бүрийн малын тэжээл шинээр тариалах нөхцлийг бүрдүүлнэ.
9. Улийн цагаан оготнотой тэмцэх ажлыг үргэлжлүүлнэ.
10. Орон нутгийн онцлог шинж, иргэдийн хэрэгцээнд тулгуурласан бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, худалдаа болон бусад төрлийн үйлчилгээний бизнес эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ.
11. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг орон нутгийн иргэд, байгууллагад худалдан борлуулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.
12. Сумын төвд 20 тоннын багтаамж бүхий хөргүүртэй зоортой болно.

2.4. Байгаль орчин, газрын харилцаа

1. Сумын төвийн ногоон байгууламж, хайсан хашааг нэмэгдүүлж, усалгааны асуудлыг шийдвэрлэн “Ногоон сум болох” хөдөлгөөн өрнүүлнэ.
2. “Хашаандаа тохилог сайхан амьдарцгаая” аяныг үе шаттай зохион байгуулна.



27

3. Хог хаягдлын менежментийг сайжруулах талаар холбогдох журмуудыг боловсруулан хэрэгжүүлж, хог хаягдлыг ангилан ялгах, хуванцар савны хаягдлыг бууруулах ажлыг үргэлжлүүлнэ.
4. Бургаст хавцгайд мод, бутыг нэмэгдүүлж хамгаалалтын хашаа барьна.
5. Хогийн цэгийн нийт талбайг нэмэгдүүлэхгүйгээр хашаална.
6. Газрын мэдээллийн санг нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ.

Гурав. Засаглалын бодлого

3.1. Төрийн алба, хууль эрх зүй

1. Төрийн байгууллагуудын иргэнд ойр төрийн үйлчилгээг бий болгох арга хэлбэрийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ. /Угтах үйлчилгээ, хөтөч үйлчилгээ гэх мэт.../
2. Төрийн байгууллага, албан хаагч бүрийн нэр хүнд, тэдний харилцаа хандлага, үйлчилгээний чанарыг иргэдийн сэтгэл ханамж, үнэлгээгээр үнэлж, ажлын хариуцлагыг өндөржүүлнэ.
3. Төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж, хөгжүүлэх, мэргэшүүлэх танхимын болон зайн сургалтын хүрээг нэмэгдүүлж, төрийн албаны мэргэшсэн, чадварлаг байх нөхцлийг дэмжинэ.
4. Жилд сумын төвд 2-оос доошгүй удаа, хөдөөгийн багуудад 1 удаа "Иргэдээ сонсоё" нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулна.
5. ИТХ, ЗДТГ болон бусад байгууллагуудын компьютер тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үе шаттай шийдвэрлэнэ.
6. "Иргэний танхим"-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, үйлчилгээний төрөл, чанарт ахиц гаргана.
7. Мал, орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Малчдын бүлэг", "Сайн хөршийн холбоо"-г үр дүнтэй хэрэгжүүлнэ.

ХАЙРХАНДУЛААН СУМЫН МАНЫН ХОРОО